

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (9)

2021.06.07

## БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХЛЭЛИЙН ХУРАЛ БОЛЛОО



Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх Эхлэлийн уулзалт Хангарди ордны НИТХ-ын Их Танхимд амжилттай болж өнгөрлөө. Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирлын орлогч С.Зоригт уулзалтыг нээж хэлсэн үгэндээ “Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Монголын МСС болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны хооронд “Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ” байгуулсан ба газар чөлөөлөлтийг барилга угсралтын ажил эхлэхээс өмнө бүрэн дуусгах нь нэн чухал” хэмээн онцолсон юм.

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан](#)

## “СУМЫН ХӨГЖИЛ: ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ” ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ 59 СУМАНД ХЭРЭГЖИХЭЭР БОЛЛОО

Сумдыг инженерийн дэд бүтэцтэй болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрдүүлэх зорилгоор “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд нэр бүхий 19 аймгийн 59 сумыг дэд бүтэцтэй болгох юм. Сумдыг хүн амын тоо, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, байгаль экологийн эмзэг байдал, газар нутгийн даац, ус хангамжийн эх үүсвэр, усны нөөц зэргийг харгалзан сонгосныг Засгийн газрын хэвлэлийн албнаас мэдээллээ. Төслийн хүрээнд 2024 он гэхэд нэр бүхий сум орон нутгийн иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэх, дулаан, хэрэгцээний халуун устай болгох, сумын төвийн орон сууц, худалдаа, үйлчилгээний зэрэг барилга, байгууламж, айл, өрхийн 40 хүртэлх хувийг буюу нийт 7 800 өрхийн 31 мянган хүнийг төвлөрсөн шугам сүлжээтэй болгох, шилжилт хөдөлгөөнийг бууруулж, сумандаа ая тухтай амьдрах боломж бүрдүүлэх, бичил өрхийн үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдүүлэх зэрэг зорилт тавьж байна. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 238 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд жил бүрийн улсын төсөв, гадаадын зээл, тусламжаас санхүүжүүлэх юм байна.

[Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, МОНЦАМЭ агентлаг](#)

## “УСНЫ ЗАСАГЛАЛЫГ ШИНЭЛЭГ АРГА ЗАМААР ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА



Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Азийн хөгжлийн банктэй байгуулсан санамж бичгийн хүрээнд “Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Монгол Улсад анх удаа “Газрын доорх усыг зориудаар нэмэгдүүлэх загвар төсөл”-ийг жишиг байдлаар хэрэгжүүлж байгаа бөгөөд Хэрлэн голын сав газарт хамаарах Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт газрын доорх усны нэг ширхэг ажиглалтын цооног өрөмдөж, тоноглох ажилд тус сав захиргааны мэргэжилтэн Г.Мөнхцог хяналт тавьж, мониторингийн цооног байгуулах, багаж тоног төхөөрөмж суурилуулах, программ хангамжийг хэрхэн ашиглах талаар онол, практик хосолсон сургалтад хамрагдан, холбогдох багаж тоног төхөөрөмжийг хүлээн авчээ.

[Эх сурвалж: Хэрлэн голын сав газрын захиргаа, Азийн хөгжлийн банк](#)

## ТОВЧХОН

- УСУГ-ын Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг [“Усны тоолуурын заалт авах үйл ажиллагаа”](#) сэдвээр хүргэж байна. [Эх сурвалж: УСУГ](#)
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар Геодези, усны барилга, байгууламжийн газар, Хот тохижилтын газар зэрэг Захирагчийн ажлын албаны чиг үүрэг бүхий албан хаагчдын төлөөлөлтэй уулзаж, санал солилцсон байна. Уулзалтын үеэр ГУББГ-ын дарга Л.Ариунтуяа байгууллагын үндсэн чиглэл, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж, нэн шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт, машин механизмын асуудлыг шийдвэрлэх, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх тал дээр Нийслэлийн Засаг даргаас дэмжлэг хүсчээ. [Эх сурвалж: Геодези, Усны барилга байгууламжийн газар](#)

## УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

- Хот, суурин газрын усны менежментийн асуудлаарх дэлхийн хамгийн том арга хэмжээнүүдийн нэг болох “Сингапурын Олон улсын усны долоо хоног” 2021 оны 6 дугаар сарын 22-ноос 7 дугаар сарын 2-ны хооронд цахимаар зохион багуулагдана. [Эх сурвалж: SIWW](#)